

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАТАЙ
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2018 оны 04 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Боловсролын зээлийн сан, түүнийг төлөөлж захирал (цаашид "сан" гэх), нөгөө талаас төлөөлж магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллага *Монгол Улсын Их Сургууль* (цаашид "сургууль" гэх) нар (хамтад нь "талууд" гэх) Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцож хамтран ажиллах гэрээг (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1.2. "Оюутны хөгжлийн зээл"-ийн хөтөлбөрийн хүрээнд сан, оюутан, суралцагчдын хооронд байгуулах гэрээний зориулалт, нөхцөлийн дагуу зээл олгох үйл ажиллагаа, эргэн төлөлт, санхүүжилт, сургалтын төлбөртэй холбоотой харилцааг зохицуулахад гэрээний зорилго оршино.

Хоёр. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

2.1. Сантай оюутны хөгжлийн зээлийг магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн өдрийн ангид суралцаж байгаа оюутан, суралцагчдад зээлийг үргэлжлүүлэн олгож болно.

2.2. Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолоор баталсан "Оюутны хөгжлийн зээлийг олгох, эргэн төлүүлэх журам"-ын 2.4-т заасан шаардлага хангасан оюутан, суралцагчидтай гэрээ байгуулж зээлийг олгоно.

2.3. "Оюутны хөгжлийн зээл"-ийг олгох нийт хугацаа нь тухайн (мэргэжлийн) сургалтын хөтөлбөрт заасан жилээс хэтрэхгүйгээр хичээлийн жилийн улирал тутамд дээрх шаардлага хангасан тохиолдолд олгоно.

2.4. Зээл хүсэгч нь зээлийн хүсэлтээ зээл авах шаардлага үүссэн үед суралцаж буй сургуулиараа дамжуулан боловсролын зээлийн санд гаргаж, зээлийг сургуулийнхаа дансанд сургалтын төлбөрийн зориулалтаар шилжүүлж авна.

2.5. Зээлийн эрсдэлийн сангийн дансны хөрөнгийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

2.6. Оюутны зээлийн 5 хувийг зээл бүрэн төлөгдөх хүртэлх хугацаанд банкин дахь зах зээлийн хүүгийн нөхцөлөөр зээлийн эрсдэлийн сангийн дансанд байршуулна.

2.7. Сан нь дараах тохиолдолд зээлийн эрсдэлийн санд байршуулсан хөрөнгөнөөс зээлдэгчийн зээлийн хугацаа хэтрэлтийн төлбөрийг тухайн сургуулиар төлүүлнэ. Үүнд:

2.7.1. Зээлийн эргэн төлөлт 90 ба түүнээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн;

2.7.2. Зээлийн гэрээний хугацаа дуусахад зээлийн төлбөр төлөгдөөгүй;

2.7.3. Сан нь зээлдэгчтэй байгуулсан гэрээнд заасан үндэслэлээр гэрээг хугацаанаас өмнө цуцалсан.

2.7.4. Зээлийн эрсдэлийн сангаас сургуулиар төлүүлэх мөнгөн дүнгийн нийт хэмжээ нь тухайн оюутанд олгосон зээлийн 5 хувиас хэтрэхгүй байх;

2.8. Сантай хамтран төгсөгчдийн зээлийн эргэн төлөлт, ажил эрхлэлт, орлогын түвшин, төгссөн мэргэжлээрээ ажиллаж байгаа байдал зэрэг хүчин зүйлийг хамарсан зээлийн эдийн засаг нийгмийн үр ашиг, нөлөөллийн судалгааг зохион байгуулах;

2.9. Зээлийн талаарх мэдээлэл, танилцуулгыг оюутан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид хүргэх ажлыг зохион байгуулах;

2.10. Зээлийг олгох, төлүүлэх талаар Сантай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;

2.11. Сургууль нь зээлдэгч сургуулиа төгсөхөөс 1 /нэг/ сарын өмнө зээлийн эргэн төлөлтийн хуваарийг батлах ажлыг Сантай хамтран зохион байгуулна.

Гурав. БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Сан нь "Оюутны хөгжлийн зээлийн журам"-ын зохицуулалтыг мөрдөж ажиллахаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Магадлан итгэмжлэгдсэн сургуулийн албан хүсэлтийг үндэслэн хамтран ажиллах гэрээ байгуулах;

- 3.1.2. Зээлийг байнга, тасралтгүй олгох арга хэмжээний хүрээнд зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх;
- 3.1.3. Сангийн мэдээллийн нэгдсэн системд оюутан, суралцагчийн мэдээлэл оруулах, өөрчлөх, зээлийн мэдээлэл авах эрхийг тухайн сургуульд олгох;
- 3.1.4. Сургалтын төлбөрийг улирлаар тооцон санхүүжүүлэх;
- 3.1.5. Зээлийн дүнгийн 95 хувийг банкин дахь сургуулийн сургалтын төлбөрийн орлогын дансанд, 5 хувийг зээлийн эрсдэлийн сангийн дансанд тус тус шилжүүлэх;
- 3.1.6. Зээлдэгч зээлийг бүрэн төлж барагдуулсан тохиолдолд ажлын 14 /арван дөрөв/ хоногийн дотор зээлийн эрсдэлийн санд байршуулсан 5 хувийн төлбөрийг сургуулийн сургалтын төлбөрийн орлогын дансанд шилжүүлэхийг сургуульд зөвшөөрөх;
- 3.1.7. Зээл эрсэдсэн нөхцөлд тухайн зээлдэгчийн эрсдэлийн санд байршуулсан дүнгээр зээлийг сургуулиар төлүүлэх;
- 3.1.8. Сургууль нь энэ гэрээний 2.5, 4.1.7-г зөрчсөн нөхцөлд Сан дараагийн зээлийн санхүүжилтээс түүнтэй тэнцэх дүнгээр мөнгийг хасаж шилжүүлэх;
- 3.1.9. Зээлийн харилцаатай холбоотой асуудлаар сургуулиас шаардлагатай мэдээ, тайланг гаргуулах, хяналт шинжилгээ үнэлгээний аудит хийх ажлыг зохион байгуулж, зээлийн талаарх мэдээлэл, танилцуулгыг олон нийтэд тогтмол хүргэх;
- 3.1.10 Зээлийн шинжилгээ судалгааг хийж, зээлийн хувийн хэргийг бүрдүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу оюутан, суралцагчтай зээлийн гэрээг байгуулж, зээлийн эргэн төлөлт, чанар, эрсдэлд хяналт тавьж ажиллах.

Дөрөв. СУРГУУЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Сургууль нь "Оюутны хөгжлийн зээлийн журам"-ын зохицуулалтыг мөрдөж ажиллахаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.1. Сангийн мэдээллийн системд сургалтын хөтөлбөр, оюутны шилжилт хөдөлгөөн, дүн, холбогдох бусад мэдээллийг тухай бүр тогтмол оруулан байнга шинэчилж, оюутны мэдээллийн үнэн зөв байдлыг хангах;

4.1.2. Зээлд “Оюутны хөгжлийн зээл”-ийн журмын хүрээнд шаардлага хангасан зээл хүсэгчийг хамруулах ба шаардлагатай тохиолдолд оюутны тодорхойлолтыг гаргаж өгөх;

4.1.3. Зээлээр суралцагчийн сурлагын голч дүн шаардлага хангаагүй тохиолдолд зээлийг дараагийн улирлуудад голч дүнгийн шаардлага хангах хүртэл олгохгүй ба сургууль нь тус оюутанд энэ талаар шуурхай мэдэгдэх;

4.1.4. Зээлийн комисс /5-аас дээш хүнтэй/ байгуулж, зээлд хамрагдах хүсэлт гаргасан оюутан, суралцагчдаас бичиг баримтыг хүлээн авч хянан, шаардлага хангасан зээл хүсэгчийн материалыг Боловсролын зээлийн санд хүргүүлэх;

4.1.5. Банкинд сургуулийн сургалтын төлбөрийн орлогын болон зээлийн эрсдэлийн сангийн данс тус тус нээх;

4.1.6. Зээлийн эрсдэлийн санд байршуулсан хөрөнгөнөөс зарлагын гүйлгээ гаргахгүй бөгөөд зөвшөөрөлгүй гаргасан тохиолдолд өөрийн хөрөнгөнөөс нөхөж байршуулна. Хэрэв байршуулаагүй тохиолдолд Сан дараагийн зээлийн санхүүжилтээс хасаж шилжүүлэхийг зөвшөөрөх;

4.1.7. Энэ гэрээний 2.7-д заасан нөхцөл бий болсон тохиолдолд тухайн оюутны зээлийн эрсдэлийн санд байршуулсан мөнгөн дүнгээр зээлийн төлбөрт төлөх;

4.1.8. Эрсдэлийн сангийн хөрөнгийн тайланг Санд улирал бүр хүргүүлэх;

4.1.9. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг хагас жил, жилээр хийж Санд тайлагнах;

4.1.10. “Оюутны хөгжлийн зээл”-ийг үйлчилгээний шинэ багц бүтээгдэхүүн болгож тасралтгүй, найдвартай, хөнгөн шуурхай үйлчлэх талаар маркетинг, менежментийн байнгын үйл ажиллагааг зохион байгуулах;

4.1.11. Зээлийн гэрээнд оролцогч талуудаас гэрээг цуцлах, дуусгавар болгох, түдгэлзүүлэх тухай хүсэлт, шийдвэр гаргасан тохиолдолд ажлын 5 өдөрт багтаан нөгөө талд мэдэгдэх;

4.1.12. Оюутан шилжих, чөлөө авах, бусад шалтгаанаар хичээлд суухгүй болсон тохиолдолд энэ талаарх мэдээллийг ажлын 5 хоногийн дотор Санд цахимаар болон бичгээр мэдэгдэнэ. Сургуулиас хасагдсан, сургуулиа орхисон суралцагчийн мэдээллийг хугацаанд нь өгөөгүйн улмаас улсын төсөвт учруулсан хохирлыг сургууль хариуцан дараа улирлын зээлийн санхүүжилтээс суутгуулан барагдуулах;

4.1.13. Зээлдэгч зээлийг бүрэн төлж барагдуулсан тохиолдолд зээлийн эрсдэлийн санд байршуулсан 5 хувийн төлбөрийг тухайн сургуулийн сургалтын төлбөрийн дансанд шилжүүлэх зөвшөөрлийг сангаас хүсэх.

Тав.БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

5.1. Сургууль нь зээл хүсэгчээс дараах материалыг бүрдлийн дагуу хүлээн авч боловсролын зээлийн санд хүргүүлнэ. Үүнд:

- 5.1.1. Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 5.1.2. Зээл хүссэн, эргэн төлөхөө илэрхийлсэн өргөдөл;
- 5.1.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын батламжийн хуулбар;
- 5.1.4. Голч дүнгийн тодорхойлолт;
- 5.1.5. Төлбөрийн нэхэмжлэхийн эх хувь;
- 5.1.6. Тухайн улиралд судалж байгаа хичээлийн багц цагийн баталгаажуулсан жагсаалт;
- 5.1.7. Ирээдүйн зорилгоо тодорхойлох ЭССЭ.

Зургаа. БУСАД

- 6.1. Талууд зээлийн үйлчилгээний талаарх аливаа асуудлаар харилцан зөвшилцөж ажиллана.
- 6.2. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална. Эх хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.
- 6.3. Талууд гэрээний биелэлтийг санхүүгийн жил тутам дүгнэнэ.
- 6.4. Талууд шаардлагатай гэж үзвэл энэ гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэ гэрээний салшгүй хэсэг болно.
- 6.5. Энэ гэрээнд зааснаас бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг баримталж зохицуулна.

6.6. Энэ гэрээний заалттай холбоотой маргааныг талууд харилцан тохиролцож үл маргах замаар шийдвэрлэх бөгөөд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.7. Талууд гэрээний хүрээнд олж авсан, аливаа мэдээллийг шууд болон шууд бус замаар, өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн нөгөө талдаа хохирол учруулах зорилгоор ашиглахгүй, гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Боловсролын гэрээний сангийн
захирал:



Утас: ... 99096868.

Монгол Улсын Их Сургуулийн
захирал:



Утас: ... 99113638.